

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Уүшийн Чойжамц	Дугаар	L006
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сүм	
Төрсөн газар	Дундговь аймгийн Сайнцагаан сүм	Төрсөн он	1924
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хорин хурал буюу Хорин Ганжуур жас	Сүм хийдийн дугаар	ДУСЦ 048
Одоогийн сүм хийд	Дашгэмдэллин	Сүм хийдийн дугаар	ДУМХ 043
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Сайнцагаан сумын Хорин Ганжуур жас

Ганжуур хийд Дундговь аймгаас баруун тийш 30-аад км-т, одоогийн Сайнцагаан сумын нутаг байсан. Хуучнаар Дайчин Бэйсийн хошуу. Би тэнд анх таван настай сахил хүртээд найман настайгаасаа сууж эхлээд шажин хураагдтал 13 нас хүртлээ таван жил суусан.

Ганжуур хийдэд Манла, Майдар, Нүгнээ, Цогчэн, Хайллан, Зүүний гэсэн таван дуган байсан. Нийтдээ нэг 100 гаруй ламтай байсан. Хийдийн эргэн тойрны тахилгатай газрууд гэвэл Сайнцагааны овоо гэж тахидаг овоо байсан. Амаржаргалан гэж дацангийн өөрийн тахидаг овоо бий. Ганжуурын сууриннд ойрхон 3 км-н зйтэй байсан. Одоо энгэр дээр нь суврага босгочихсон байгаа.

Хийдийн гол шүтээн нь Гомбо, Лхам сахиустай айл байсан юм. Манай хийдэд Дайчин бэйсийн хошууны лам нар өөрсдөө шууд суудаг байсан. Тэнд байсан улсуудаас хэлмэгдэлд цугаараа орсон. Ганцхан Бөх дархан лам гэдэг хүн байсан. Тэр лам л хэлмэгдэлд орохоос өмнө таалал төгссөн юм. Хийдийн хамба нь миний багш

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цанлиг гэдэг хүн байсан. Олон сайхан унзад нар байсан. Самдан унзад гуай гэж нэг эмч лам гол их унзад байсан. Хэлмэгдэл эхлээгүй байхад хоёр жилийн өмнө манай хийдийн тэргүүн татагдсан шүү. Тэрнээс хойш хоёр жил болсны дараа 1929 (1939) он юм уу даа тэгээд л шажин хаагдсан. Манай хийдэд зурхайч ч байсан. Маарамба эмч ч байсан. Мэргэлдэг ч хүн байж л байсан.

Хийдийн баруун зүүн талд мөн хойд талд нь 7-9 суварга байсан. Ном барладаг байсан. Зүүний дуган хавьд ном барлах газар байсан. Алтангэрэл, Жадамба зэрэг том ном бол барлахгүй байх. Доржзовд зэрэг уншлагын ном л барладаг байсан. Ер манай хийд бол уншлагын л хийд байсан. Сургалтын ямар нэгэн дацан байгаагүй. Том том багшдаа шавь орсон хүн мэргэ төлөг заалгаж л байсан байх.

Зуны цагийн 15-нд эхлээд 15-нд дуусдаг 45 хоногийн хайлантай байсан. 29-нд Хангал хурна. Зүн намрын цагийн жасааны хурал гэж байсан. Дандаа уншлага. Цогчэндоо өдөр бүр уншлагатай. Зуны цагийн магтаал уншина. Ламын буулгасан гүрмийг гол дугандаа уншина. Цагаан сараар 25-аас эхлээд 108 цангаа цохиод адислага хийнэ. Адислагаа хийчихээд Арван хангалаа хоёр хоёроор нь бүтэн хураад тэгээд Цэдэр Лхамаа битүүний шөнө дагнаж хураад шинийн нэгний өглөө дугандаа золгочиоод нэг завсар гаргаж гэртээ харьж золгочиоод үдээс хойно эргээд Чонпрүлжона гэдэг нэртэй 15 хоногийн ерөөлөө хурна. 15-ныхаа хурлыг арван тав хоног саадгүй бүтэн хурдаг тийм л дацан байсан. Цамгүй. Майдар гардаг байсан. Майдарыг тухайн үеийн цаг улирлын байдалд тохируулаад ихэнхдээ зуны дунд сард эргэдэг байсан. Говь хээрийн нутаг болохоор цаг гандуу байвал хэд хоног хойшуулдаг, урагшлуулдаг. Тэр дацангийн тэргүүн ламын мэдлийнх байсан. Майдар эргэхэд сүсэгтнүүд их ирнэ. Цагаан идээг хийдээс болон мөн сүсэгтнүүд бэлтгэдэг байсан. Ганжуур эргэдэг байсан. Мөн цаг үед тохируулж эргэдэг байсан. Уг нь бол жилдээ тогтмол ганц л эргэдэг. Гэхдээ хүн Ганжуур эргүүлнэ гээд хандив энэ тэр өргөдөг байсан. Тэгэхэд нь мөн эргэнэ. Хүрээгээ тойрно. Сударнуудаа Майдарын тэргэн дээр ачаад эргэнэ. Их ламын шийдээр ханиад томуу, хижиг томуу алив нэг юм хаахад голдуу Ганжуур эргэж байсан. Нүгнээ сахидаг байсан. Зүүний дуган гэдэг чинь Нүгнээн дуган байсан юм. Сахиусны дуганыг болсон, хятад цэнхэр зөнгөөр барьсан. Бусад нь дандаа модон дуган. Давхар дуган бол байхгүй. Гэхдээ дээрээ огторгуй гээд нэг жижиг давхар шиг юм бий. Тэндээ Майдарын баг энэ тэрийг хийдэг. Ганцхан дуган тийм байсан.

Манай хийдийн ойролцоо хойхно нь Мөхийн дацан гэж байсан. Майдартай, цамтай хийд байсан. Зүүхэнтээ Нарангийн дацан гэж байсан. Бас их гоё цамтай газар байсан. Мөн одоогийн Дундговь аймгийн төвийн байгаа газар Зоогийн дуган гэж байсан. Хоорондоо 30 орчим км-н зйтай байсан. Харин Мөх, Ганжуур хоёр бол ойрхон байсан. Манай хийдэд зоч ганц нэг л байсан. Мөх зоч нарын тусгай дугантай. Мөхөд бол эрэгтэй эмэгтэйгүй зоч болсон байсан. Мөхөд дуганаа тойрсон шавар хэрмэн хашаа байсан.

Тэр үеийн лам нарын амьдрал яахав дээ. Олон түмний юмаар бүтдэг байсан. Тэгэхдээ болдог л байсан байлгүй. Юм дутагдаж байна гэж эрэл сурал болж гүйлгээ л лав хийгээгүй юм. Лам нар байшин гэртэй. Дуган дацангүүддээ тийм ч ойр биш суудаг байсан. Энгийн айлуудыг горломын дотор буулгахгүй. Энгийн айлууд хийдээс нэлээд зйтай байдаг байсан. Хийд 1939 онд бүрэн хаагдсан. Лацдаж ломбодоод л, лам нар нь

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

баригдаад. Нэг хоёр сарын дараа бутраагаад л авсан байх. Дуганын модыг сүм руу зөөж барилгад ашигласан. Бурхан шүтээн, ном судруудыг нь нууцаар шатаасан.

Би 13 настай хар болсон. Мал малласан. Бүлгэмд явж монгол бичиг, латин үсэг, сүүлийн үест нь шинэ үсэг заалгасан. Хорь хүрээд 1944 онд цэрэгт явсан. Цэрэгт таван жил болсон. Түрүү мичин жил гэдэг тэр зуднаар чинь би цэрэгт байсан. Эргээд ирэхэд унах унаагүй, идэх хоолгүй, ачих тэмээгүй бүгд хоосон болсон байсан. Амьдрахын эрхэнд элдвийн ажил хийгээд түлээ модонд явах, ан гөрөө хийх зэргээр амьдарч байсан. Жаал дэгжиж хөгжөөд, бололцоотой болоод тэгээд л нэгдэл буй болсон доо. Нэгдэлд аж ахуйн ажил гээд янз бүрийн л юм хийж байлаа. 1945 оны чөлөөлөх дайнд оролцож байсан. 1990 онд хэдэн хөгшчүүл нийлж Дундговийн төв дээр одоо байгаа Дашгэмдэллин гэдэг хийдийг сэргээсэн юм. Одоо хөгжиж дэгжиж байгаа. Монгол улсад байгаа шинээр буй болсон дацангуудаас энэ жилд 1-р байр эзэлсэн гэсэн. Хоёр ч сайхан дугантай хийд байгаа. Одоо манай Ганжуур хийдэд сууж байсан хүмүүсээс нэг ч хүн байхгүй. Манай хийдээс олон хүн баригдсан.